switchasia
Funded by the European Union

FONDATION Abbé Pierre

GLOBAL ALLIANCE FOR GREEN AND GENDER ACTION

AFD



БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА

ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

geres
ACTING FOR CLIMATE SOLIDARITY

BEEC

MNCA 15 anniversary

MGFC

MONGOLIAN WOMEN'S FUND

АГУУЛГА

I. “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн тухай 1

II. Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн мэдвэл зохих суурь мэдээлэл 5

III. Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийг чадавхжуулах тухай 7

IV. Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах тухай 9

V. Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулааалгын ажил гүйцэтгэхэд хүргэх зөвлөмж. 25

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр гаргав. Дурдагдсан аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг “Дулаан шийдэл” төсөл бүрэн хариуцах бөгөөд Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

Улаанбаатар хот
2024 он

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

Европ, Африк, Ази тивд 40 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй эрчим хүч, тогтвортой хөгжлийн чиглэлээр мэргэшсэн олон улсын төрийн бус байгууллага

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Барилга Архитектурын Сургуулийн харъяа, Барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй техник технологийг нэвтрүүлэх зорилготойгоор сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төв

2009 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй барилгын салбар дахь хамгийн том нэгдэл бүхий гишүүддээ болон нийгэмд үйлчилдэг, үйл ажиллагаа нь төрөөс хараат бус, ашгийн бус байгууллага

Үндэсний ногоон санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг нэгдсэн бодлого, стандартаар хангаж, хөнгөлөлттэй нөхцөлтэй ногоон зээлээр санхүүжүүлэх зорилтын хүрээнд 2014 онд байгуулагдсан.

2000 онд үүсгэн байгуулагдсан, төрөөс хараат бус, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, нийтийн сан бөгөөд эмэгтэйчүүд, охидыг хүчирхэгжүүлж, нийгмийн өөрчлөлт бий болгохын төлөө эмэгтэйчүүдийн ТББ, орон нутгийн бүлгүүдэд дэмжлэг үзүүлдэг байгууллага.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАГВАР

1. Дуудлагын төв рүү (7505-2000) залган захиалга өгч дулаалгын зөвлөх дулаан алдагдыг хэмжиж үнийн санал өгнө



2. Дулаалгын зөвлөхийн баталгаат үнийн саналыг Банк/ББСБ-д үзүүлэн зээл хүснэ



3. Зээл гармагц ажил гүйцэтгэх дулаалгын бригадтай гэрээ байгуулна



4. Материал хүлээн авснаас хойш гэрээний хугацаанд дулаалгын ажлыг хийж гүйцэтгэнэ.




5. Дулаалгын ажлыг гүйцэтгэсний дараа эрчим хүчний аудитор гэрчилгээ гаргана.



*Хувиараа санхүүжүүлж байгаа тохиолдолд 2-р алхмыг алгасан ажил гүйцэтгэгч бригадын ахлахтай тохиролцон, гэрээний дагуу төлбөрөө шилжүүлнэ.

2023 оны Өвлийн хэмжилтийн үр дүн



“Дулаан шийдэл II” төсөл нь дулаалгын ач холбогдлыг таниулах, дулаалгатай болон дулаалгагүй хувийн сууцны халаалтын түлш, эрчим хүчний хэрэглээ, хүлэмжийн хийн ялгарал, дотоод орчны агаарын чанар зэргийг хэмжиж үнэлэх зорилгоор Улаанбаатар хотын гэр хорооллын 100 айл өрхийн дунд жил бүр өвлийн хэмжилтийн судалгаа зохион байгуулдаг.

Дулаалга хийлгэснээр нэг айл дунджаар:

- Түлшний хэрэглээ 2 дахин багассан
- Дотор агаарын хэм 2 дахин удаан хадгалагддаг болж тав тух нэмэгдсэн
- Жилийн халаалтын зардлаас 300,000₮-ыг хэмнэсэн
- Монгол улсыг 3 тойрохтой тэнцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан

7505-2000 | Дулаан шийдэл төсөл | www.dulaalga.mn

ДУЛААН ШИЙДЭЛ II
ТӨСӨЛ 2022 - 2026

Ерөнхий зорилго

Монгол улсын барилгын салбарт нөөцөд хэмнэлттэй, бохирдуулагч багатай туршлагыг нэвтрүүлэх зорилгоор хүртээмжтэй, тохиромжтой бүтээгдэхүүнийг хөгжүүлж, санхүүгийн шийдлийг санал болгон хувийн сууцны эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлж, түлшний хэрэглээ, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

Санхүүжүүлэгч байгууллагууд

switchasia

Funded by the European Union

GLOBAL ALLIANCE FOR GREEN AND GENDER ACTION

FONDATION Abbé Pierre

AFD

Зорилт

1. Олон нийтэд эрчим хүчний хэмнэлтийн талаарх мэдээлэл хүргэх, чадавхыг нэмэгдүүлэх
2. Хувийн сууцанд тохирсон эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг боловсруулах
3. Ногоон зээлийн хүртээмж, сувгийг нэмэгдүүлэх
4. Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр БЖДБ-үүдийг чадавхжуулах
5. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд хэрэгжүүлж болохуйц бүрэн туршигдсан арга зүй, техникийн багцыг бий болгох
6. Төслийн цаашдын тогтвортой байдлыг хангаж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэх

Төслийн Фейсбүүк хуудас

Хүрэх үр дүн:

- **5,900** Өрхөд эрчим хүчний хэмнэлттэй шийдэл хэрэгжүүлэх
- **1,000** Өрхийг ногоон зээлд зуучлах
- **160** Барилгын салбарын БЖДБ эрхлэгчдийг чадавхжуулах
- **11** Банк, ББСБ, хадгаламжийн бүлэгтэй хамтран ажиллах
- **5** Бүтээгдэхүүн хөгжүүлэх
- **1** Аймагт үйл ажиллагааг өргөжүүлэх
- **2.2 сая** Хүнд нөлөөллийн болон маркетингийн ажлаар хүрч ажиллах

Зорилтот бүлгүүд

- Гэр хороололд амьдарч буй иргэд
- Орон нутгийн захиргаа
- Барилгын материал нийлүүлэгчид
- Барилгын салбарын БЖДБ эрхлэгчид
- Санхүүгийн байгууллагууд
- Олон улсын хөгжлийн агентлагууд

Эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүд

Дулаан алдагдлын хэмжилт: Энгийн болон камертай	Дээврийн эрдэс хөвөн дулаалга: 5см, 10см, 15см, 20см	Ханын дулаалга: Эрдэс хөвөн, EPS хөөсөнцөр	Цонх суурилуулалт	Суурийн дулаалга: XPS хөөсөнцөр	Шалны дулаалга: XPS хөөсөнцөр +	Эрчим хүчний хэмнэлттэй шинэ шийдлүүд


Хялбар шийдэл аян:

Хялбар, хямд аргаар гарын доорх материал ашиглан байшингаа дулаалах "Хялбар шийдэл" аянг жил бүр зохион байгуулдаг. Уг аян нь дулаалгын ач холбогдол болон дулааны тав тухыг олон нийтэд таниулах зорилготой.

- **1,445** өрх дулаалгын хялбар шийдлийг хэрэгжүүлэв
- **249** өрхийн дээврийг 5 см эрдэс хөвөнгөөр дулаалав
- **200** өрх цонх, хаалганы багцаар дулаалав
- **18,680** гишүүдтэй "Дулаалгын хялбар шийдэл" Фэйсбүүк групп

II. БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН МЭДВЭЛ ЗОХИХ СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ ГЭЖ ЮУ ВЭ?



Хүний үйл ажиллагаанаас шалтгаалж дэлхийн уур амьсгалын тогтолцоонд гарч буй өөрчлөлтийг уур амьсгалын өөрчлөлт гэдэг. Уур амьсгалын өөрчлөлт нь нүүрстөрөгчийн давхар исэл болон метан зэрэг хүлэмжийн хийн ялгарлаас үүдэн бий болдог. Уур амьсгалын өөрчлөлт нь гамшгийн давтамж нэмэгдэх, ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, гол горхи ширгэх зэрэг үр дагаврыг бий болгож, бидний амьдралд сөргөөр нөлөөлж байна. Дэлхий бол тэр чигтээ нэг цөм бөгөөд нэг бүсэд бий болсон өөрчлөлт нь дэлхийн бусад бүх хэсэгт нөлөөлдөг юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ АГААРЫН БОХИРДОЛТОЙ ХОЛБООТОЙ ЮУ?



Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол хоёр нь хоорондоо салшгүй холбоотой. Уур амьсгалын өөрчлөлтийг хүлэмжийн хийн ялгарал бий болгодог. Харин хүлэмжийн хий нь байшин сууцыг нүүрс түлж халаах, бензин/түлш хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл ашиглахад ихээр ялгардаг. Айл өрхүүдийн түлшний хэрэглээ, нам даралтын зуух, тээврийн хэрэгсэл, цахилгаан станц зэргээс хүлэмжийн хий ялгараад зогсохгүй утаа, нарийн ширхэгт тоосонцрыг үүсгэн, агаарыг бохирдуулдаг. Бидний амьдарч буй Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотуудын тоонд багтдаг бөгөөд агаарын бохирдлын 60 гаруй хувь нь түлшний хэрэглээнээс үүдэж байна.

АГААРЫН БОХИРДОЛД ХЭН ХАМГИЙН ИХ ӨРТӨЖ БАЙНА ВЭ?



Амьсгалын замын өвчин, уушгины хатгалгаа, үрэвсэл зэргээс шалтгаалсан өвчлөл, нас баралтад агаарын бохирдол ихээр нөлөөлж байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хотын оршин суугчдын 10000 хүн тутамд амьсгалын замаар халдвар авах тохиолдлууд 2.7 дахин нэмэгдсэн.

ЭХ СУРВАЛЖ:

1. *БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан, 2018. Боловсролын салбарт агаарын бохирдлын нөлөөллийг шуурхай үнэлэх. 2018 оны 8-р сар https://www.unicef.org/mongolia/ media/911/file/Agaariin_bohirdol_report_mn.pdf*
2. *Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл IV боть, Улаанбаатар, 2021 он, http://www.hdc.gov.mn/file-category/56/*

АГААРЫН БОХИРДОЛД ИЛҮҮ ӨРТӨМТГИЙ БҮЛГҮҮДИЙГ ТОДОРХОЙЛБОЛ:



ӨНДӨР НАСТАН:

Өндөр настай хүмүүсийн эрүүл мэндэд агаарын бохирдол сөргөөр нөлөөлж, амьсгалын замын, зүрх судасны, төв мэдрэлийн системийн өвчлөл, харшлын, удамшлын эмгэг, хавдар зэрэг өвчний тархалт, тохиолдлын түвшнийг ихэсгэж байна. Утаа, нарийн ширхэгт тоосонцор нь хүний амьсгалах агаарыг бохирдуулж, хүчилтөрөгчийг багасгаж, улмаар даралт ихсэх, цус харвах зэрэг өвчлөлийн эрсдэлийг нэмэгдүүлдэг.



ХҮҮХЭД:

Улаанбаатар хотын агаарын бохирдол өндөртэй, гэр хороолол ихтэй дүүрэгт амьдардаг хүүхдүүдийн уушгины ажиллагаа хөдөө орон нутагт амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад 40%-аар бага байна. Агаарын бохирдлын улмаас хүүхдүүд бронхит, астма зэрэг суурь өвчтэй болж, хичээл сургуульд явж чадахгүйд хүрч, улмаар сурч, хөгжих бусад боломжоо алдаж байна. Насанд хүрсэн хүнтэй харьцуулбал хүүхэд хурдан, илүү олон давтамжтай амьсгалдаг. Иймд уушги, амьсгалын замын өвчин тусах зэрэг эрсдэл өндөр байдаг.



ЖИРЭМСЭН ЭХЧҮҮД:

Агаарын бохирдолд жирэмсэн эмэгтэйчүүд илүү өртөмтгий байдаг. Хэвлий дэх хүүхдийн уушги, амьсгалын замд нөлөөлж, хугацаанаас өмнө төрөх, ургийн гажиг үүсэхэд нөлөөлж байна. Жирэмсэн үедээ эсвэл төрсний дараах нярай үедээ агаарын бохирдолд өртөх нь нярайд танин мэдэхүйн хоцрогдол их, бага хэмжээгээр үүсгэх эрсдэлтэй.



СУУРЬ ӨВЧТЭЙ ХҮМҮҮС:

Цус багадалт, Рахит Д витамины дутагдал, жин багатай байх, харшил, бронхит зэрэг суурь өвчтэй хүмүүст угаарын хий, тоос тоосонцор гэх мэт бохирдол сөргөөр нөлөөлж, өвчин ужгирах, эрүүл мэндийг доройтуулах эрсдэлтэй байдаг.

ДУЛААЛГА ХИЙСНЭЭР ҮҮСЭХ ДАВУУ ТАЛУУД:

- Түлш бага зарцуулж, эдийн засгийн хэмнэлт бий болно.
- Дотор агаарын чанар сайжирч, эрүүл мэндэд эерэгээр нөлөөлнө.
- Гэр бүлдээ зарцуулах цаг нэмэгдэнэ.
- Галлагаа хийх тоо буурч, гэр доторх тоос, тоосонцор багасна.
- Хүүхэд, гэр бүлийн гишүүд гэртээ даарч жиндэх, ханиад томуу тусах нь багасна.
- Гэрийн дотор агаарын хэм тогтвортой болж, гэртээ олон цагаар байх тав тух нэмэгдэнэ.

ЭХ СУРВАЛЖ:

1. *Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, 2018 он, https://www.unicef.org/mongolia/mn/report*
2. *«Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах нь» төсөл (2018-2023) НҮБ-ын Хүүхдийн сан, 2021 он, https://www.unicef.org/mongolia/mn/reports*

III. БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ТУХАЙ

ОЛГОЖ БУЙ БАГЦ БОЛОМЖ:

- Чадавхжих, хөгжих, туршлага хуримтлуулах, ажлын түүхээ үүсгэх, гүйцэтгэлээ сайжруулах боломж.
- Нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээтэй чиглэлээр харьцангуй уян хатан нөхцөлөөр ажиллаж, орлогын нэмэлт эх үүсвэртэй болох боломж.
- Бизнесээ өргөжүүлэх, харилцаа холбоогоо тэлэх, гишүүнчлэлтэй болох боломж.
- Удирдан зохион байгуулагч/ багийн үнэ цэнтэй гишүүн байх, хамтаараа нэгдсэн зорилго, зорилтуудад хүрэх боломж.
- Барилгын салбарт ажилладгийн хувьд агаарын бохирдлыг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулах, нийгмийн хариуцлагаа ухамсарлах боломж.

ЭЛСҮҮЛЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЕ ШАТ:

- Нээлттэй зарлал
- Анкетын шалгаруулалт
- Төсөл танилцуулах уулзалт
- Ярилцлага

ЭЛСҮҮЛЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Өөрийгөө хөгжүүлэх, чадавхжих, туршлага хуримтлуулах хүсэл эрмэлзэлтэй байх
- Барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах сонирхолтой байх
- Барилгын ажлын тодорхой мэдлэг, туршлагатай байх
- Хариуцлагатай, хувийн зохион байгуулалт, харилцаа, хандлага сайтай байх
- Чадавхжуулах багц хөтөлбөрүүдэд цаг заваа зарцуулан хамрагдах боломжтой байх

БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН БАГЦ:

Багц сургалт №1: “Дулаалгын ажилтан”

№	Сургалтын нэр	Сургалтын үргэлжлэх хугацаа
1	Барилгын салбар дахь жендэрийн асуудал	1 өдөр/8 цаг
2	Барилгын хог хаягдлын менежмент	
3	Дулаалгын технологи	2 өдөр/16 цаг
4	Нийт ажилтнуудад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	1 өдөр/8 цаг
	Нийт үргэлжлэх хугацаа	**4 өдөр/32 цаг**

Багц сургалт №2: “Дулаалгын зөвлөх”

№	Сургалтын нэр	Сургалтын үргэлжлэх хугацаа
1	Барилгын дулаан хамгаалалтын үнэлгээ	2 өдөр/16 цаг
2	Зах зээл, маркетинг, борлуулалт, дулаалгын платформ	
3	Бизнесээ хөгжүүлэх цогц мэдлэг олгох	2 өдөр/16 цаг
4	Удирдах ажилтнуудад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	1 өдөр/8 цаг
	Нийт үргэлжлэх хугацаа	**5 өдөр/40цаг**

“Дулаалгын ажилтан” багц сургалтад бүрэн хамрагдсан барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид “Дулаалгын зөвлөх” багц сургалтаар чадавхжих эрх үүснэ.



ЧАДАВХЖУУЛАХ БУСАД СУРГАЛТ-АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ:

- Дулаалгын ажлын дадлага
- Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх дадлага сургуулилт
- Камертай хэмжилтийн нэгдсэн дадлага сургуулилт
- Эдийн засаг, банк, санхүүгийн мэдлэгийг олгох чөлөөт уулзалт
- Бизнесийн холбоо тогтоох уулзалт, арга хэмжээ
- Спортын нөхөрсөг өдөрлөг

ДУЛААЛГЫН АЖИЛТАН/ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХӨӨР ДАДЛАГАЖУУЛАХ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ:

Дадлагад холбогдох багц сургалтуудад хамрагдсан, цаашид дулаалга, эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр ажиллах сонирхолтой хүн (цаашид дадлагажигч гэх) хамрагдана.

Дадлагажигч хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх/дулаалгын ажлын дадлагад 3 хүртэлх удаа гарна. Шаардлагатай бол нэмэлт дадлагад гарч болно.

Дадлагыг туршлагатай дулаалгын ажилтан/дулаалгын зөвлөх удирдан явуулна.

Дадлагад гарахаасаа өмнө дулаалгын үнэлгээний хуудас, дулаалгын өртөг тооцоолол, дадлагажигчийн тэмдэглэл зэрэг шаардлагатай материалыг урьдчилан бэлдсэн байна.

Дадлагажигч нь хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажил хийх бүхий л үйл явцад идэвх, зүтгэлтэй байна.

Дадлага хийсний дараа дадлагажигчийн хуудсанд сурч, мэдсэн зүйлээ тэмдэглэж, мэдлэг, мэдээллээ баталгаажуулна.

ДУЛААЛГЫН АЖИЛТАН/ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХӨӨР ДАДЛАГАЖИГЧИЙН ХУУДАС

1. Дадлагад гарсан огноо: .....
2. Дадлагад гарсан байршил: .....
3. Дадлагажигчийн овог, нэр: .....
4. Холбоо барих утасны дугаар: .....

ТЭМДЭГЛЭЛ

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Дадлагажуулсан дулаалгын ажилтан/дулаалгын зөвлөхийн гарын үсэг: .....
Дадлагажигчийн гарын үсэг: .....



IV. БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

ХАРИЛЦАХДАА БАРИМТАЛДАГ ЗАРЧИМ:

- Хүнлэг
- Зарчимч
- Нөхөрсөг

ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

ХАМТРАН АЖИЛЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

1. Технологийн дагуу чанартай, найдвартай, хариуцлагатай, үнэн бодит, сэтгэл ханамжтай, иж бүрэн үйлчилгээг үзүүлэх
2. Идэвх, санаачилгатай байх
3. Тодорхой соёл, дүрэм, журамд нийцэж ажиллах
4. Хийсэн ажлаа тайлагнаж, эргэх холбоотой ажиллах
5. Эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, ажилдаа бүтээлчээр хандах, багаар ажиллах

БАРИЛГЫН АЖИЛД ЗУУЧЛАХ ХЭЛБЭРҮҮД:

- Эрчим хүч хэмнэлтийн талаар зөвлөгөө зөвлөмж өгөх үйлчилгээ
- Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, хэмжилт, үнэлгээ хийх үйлчилгээ
- Хувийн сууцны дулаалгын ажил
- Маркетинг, идэвхжүүлэлт, төлөвлөгөөт аян, хамтын ажиллагааны хүрээн дэх барилгын ажлууд
- Барилгын экспод оролцуулах



“ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛ”-ИЙН ХҮРЭЭНД БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН “САНАМЖ БИЧИГ”

202.. оны ....-р сарын ....-ний/ны өдөр № ... Улаанбаатар хот Европын Холбооны Свич-Эшиа II хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн хүрээнд хамтран ажиллах харилцан ойлголцлын “Санамж бичиг” (цаашид “Санамж бичиг” гэх)-ийг Нэг талаас Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ (цаашид “МБҮА ТББ” гэх)-ыг төлөөлж, ...,

Нөгөө талаас барилгын бичил, жижиг бизнес эрхлэгч ..... тоот хаягт оршин суух ..... овогтой ..... (РД:.....) нь (цаашид “ББЖБЭ” гэх) нар нь 202... оны .... дугаар/дүгээр сарын ....-ний/ны өдрөөс 202... оны .... дугаар/дүгээр сарын ....-ний/ны өдрийг дуустал 1 (нэг) жилийн хугацаатай байгуулав.

НЭГ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

1.1. “Дулаан шийдэл-2 төсөл” нь Европын Холбооны Свич Эшиа II хөтөлбөрийн санхүүжилттэй, 2022-2026 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэх төсөл бөгөөд төслийг Жэрэс ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Монголын барилгын үндэсний ассоциаци ТББ, Монголын ногоон санхүүгийн корпораци, Монголын эмэгтэйчүүдийн сан зэрэг байгууллага нь түншлэн хэрэгжүүлж байна.

1.2. “Санамж бичиг”-ийн зорилго нь “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн хүрээнд Монголын нөхцөлд нийцсэн, үр ашигтай эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг зах зээлд санал болгох, нэвтрүүлэх чиглэлээр ажиллах сонирхолтой барилгын салбарт ажиллаж буй бичил, жижиг бизнес эрхлэгчид (ББЖБЭ)-ийг бүртгэх, сонгон шалгаруулах, чадавхжуулах, дадлагажуулах, чадавхыг үнэлэх, ажилд зуучлах, гүйцэтгүүлэх, гүйцэтгэлийг хянах, үнэлэх замаар бизнесийн үйл ажиллагаагаа тэлж, нэмэлт орлоготой болгоход нь дэмжлэгийг үзүүлэх зэрэг талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.3. Хамтын ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, эерэг харилцаа, хандлага, үр дүнтэй байх зарчимд тулгуурлах бөгөөд харилцан итгэлцэл дээр тогтоно.

1.4. Энэхүү “Санамж бичиг”-ийн хамрах хүрээ нь ББЖБЭ-д чиглэсэн төслийн үйл ажиллагаа, арга хэмжээгээр хязгаарлагдах бөгөөд түүнд хамаарахгүй бусад асуудлаар төслийн түншлэгч байгууллагууд нь ББЖБЭ болон аливаа харилцагчийн өмнө хариуцлагыг хүлээхгүй болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. МБҮА ТББ-ын хэрэгжүүлэх арга хэмжээ

2.1.1. МБҮА ТББ нь төслийн түншлэгч байгууллагуудын хамтаар энэхүү “Санамж бичиг”-ийг байгуулсан ББЖБЭ-ийг хувийн сууцны дулаан алдагдлыг эрчим хүчний хэмнэлттэй технологиор бууруулах чадамжтай, тодорхой мэдлэг, бодит туршлагыг хуримтлуулсан, ёс зүйтэй бизнес эрхлэгч болгохын тулд тэд нарт чиглэсэн төслийн үйл ажиллагаа, арга хэмжээг удирдан чиглүүлнэ.

2.1.2. МБҮА ТББ нь энэхүү “Санамж бичиг”-ийн хүрээнд байгуулсан үүргээ биелүүлэх, гүйцэтгэсэн ажилдаа чанарын баталгааг гаргахыг ББЖБЭ-ээс шаардана.

2.1.3. Нээлттэй бүртгэл, сонгон шалгаруулалтын үр дүнд ББЖБЭ-ийг эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулж, оролцоог хангана.

2.1.4. 2.1.3-д заасан арга хэмжээнд бүрэн хамрагдсан, тодорхой болзлыг хангасан, цаашид төсөлтэй хамтарч ажиллах сонирхлоо илэрхийлсэн ББЖБЭ-ийг бусад чадавхжуулах сургалтуудад үе шаттайгаар хамруулна.

2.1.5. 2.1.3, 2.1.4-т заасан арга хэмжээнүүдэд хамрагдсан, цаашид эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах сонирхолтой зэрэг шалгуурыг хангасан ББЖБЭ-ийг хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх хэмжилт, үнэлгээ, дулаалгын ажилд зуучилж, хамтран ажиллана.

2.1.6. Идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-ийг хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэхэд нь дэмжих зорилгоор тодорхой багаж, хэрэгсэл, төслийн маркетинг болон техникийн бичиг баримтууд зэрэг материалаар хангаж, “Дулаан шийдэл” вэб системд хэрэглэгчийн эрхийг үүсгэнэ.

2.1.7. Төслөөс зохион байгуулж буй уулзалт, арга хэмжээнүүдэд идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-ийг оролцуулна.

2.1.8. Идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-д “Сар бүрийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ, дүгнэлтийг өгөх, урамшуулах, ажлын гүйцэтгэлээ сайжруулах шаардлагыг тавьж, гүйцэтгэлийг хянана. (Хавсралт №1).

2.1.9. Веб-д суурилсан “Барилгын ажил” цахим системийг хөгжүүлж, идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-ийг МБҮА ТББ-ын гишүүн компаниуд болон бусад ажил олгогч нартай холбон зуучилна.

2.1.10. Идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-дэд төслийн үйл ажиллагааны талаар зөвлөгөө, зөвлөмжийг өгөх, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, сурталчлах, борлуулалтаа өсгөхөд нь дэмжинэ.

2.1.11. Төслийн үйл ажиллагааг сайжруулах, үнэлэх зорилгоор идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-ээс асуулга, судалгааг авах, нэгтгэн дүгнэх ажлыг зохион байгуулна.

2.1.12. МБҮА ТББ-ын дэргэдэх Салбарын үйл ажиллагаанд идэвхтэй хамтран ажиллаж буй ББЖБЭ-г оролцуулах, тэдний тогтвортой байдлыг хангах, МБҮА ТББ-д гишүүнээр элсүүлнэ.

2.1.13. Төсөлд хамрагдах эмэгтэй ББЖБЭ-ийн тоог нэмэгдүүлнэ.

2.1.14. 2.1.8-д заасан шалгуур үзүүлэлтэд хүрэхгүй байх, идэвхгүй болсон, “Гомдол хүлээж авах, барагдуулах журам” (Хавсралт №2), “Дулаан шийдэл-2

төсөл”-тэй хамтран ажиллаж буй барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчийн ёс зүйн дүрэм” (Хавсралт №3)-ийн тодорхой заалтуудыг зөрчсөн гэх мэт шалтгаантай ББЖБЭ-ийг төслийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх, төслийн бусад түншлэгч байгууллагын саналд үндэслэн нэн даруй, цаг алдалгүй “Санамж бичиг”-ийг цуцлах зэрэг болно.

2.2. ББЖБЭ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээ

2.2.1. Төслийн хугацаанд тогтвортой, эргэх холбоотой ажиллаж, төслийн түншлэгчдээс зохион байгуулж буй аливаа сургалт, уулзалт, арга хэмжээ, үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцоно.

2.2.2. “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн хүрээнд боловсруулсан технологийн зааварчилгаа, үнийн тооцооллыг ашиглан, төслийн сургалтуудаар олж авсан мэдлэг, мэдээллийнхээ дагуу хувийн сууцны дулаан алдагдлыг үнэн зөв илрүүлэх, дулаалгын өртөг, тооцооллыг үнэн зөвөөр гаргах, эрчим хүч хэмнэлтийн талаар зөвлөгөөг өгөх, дулаалгын ажлыг гүйцэтгэнэ.

2.2.3. 2.1.8-д заасан шалгуур үзүүлэлтэд хүрч ажиллах, сард хамгийн багадаа 2 хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, жилд хамгийн багадаа 2 дулаалгын ажлыг хийж гүйцэтгэнэ.

2.2.4. 2.1.6-д заасан багаж, хэрэгсэл, эд зүйлсийг зориулалтын дагуу ашиглах, бусдад шилжүүлэхгүй, ашиглуулахгүй байх, хаяж урэгдүүлэхгүй, эвдэж гэмтээхгүй байх, аль нэг талын санаачилгаар “Санамж бичиг”-ийг цуцалсан бол нэн даруй хүлээлгэн өгнө.

2.2.5. Айл өрхтэй “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ”-г зайлшгүй байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, айл өрхтэй тохиролцсон хугацаандаа ажлаа технологийн дагуу, түргэн шуурхай, чанартай хийж гүйцэтгэх, гүйцэтгэлийн явц, үр дүнг тухай бүрд нь айл өрхдөө тайлагнах, хүлээлгэн өгөх, хийж гүйцэтгэсэн ажилдаа чанарын баталгааг гаргана.

2.2.6. 2.2.2-т заасан тооцооллыг буруу гаргасан, 2.2.5-д заасан гэрээний үүргийг гүйцэтгээгүйгээс үүсэх аливаа чанарын гологдол, дутагдал, хохирлыг өөрөө бүрэн дүүрэн хариуцан арилгах, мөн ажил гүйцэтгэх үедээ айл өрхийн эд хөрөнгө зэрэгт өөрийн буруутай үйлдлийн улмаас хохирол учруулсан бол бодит хохирлыг өөрөө бүрэн дүүрэн хариуцан төлж барагдуулна.

2.2.7. Дулаалгын ажлыг хийж гүйцэтгэхдээ бригад/компаниа өөрөө удирдан зохион байгуулах, сайтар зааварчилж чиглүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, зааварчилгааг ягштал мөрдөж, аюулгүй ажиллах ба ажиллуулах, үүсэх эрсдэл бүрийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг авах, аливаа осол аваар гарсан тохиолдолд өөрөө бүрэн дүүрэн хариуцан арилгана.

2.2.8. Бригад/компанийн гишүүдийн 50-аас доошгүй хувийг сурган дадлагажуулах, аливаа ёс зүйн журам, холбогдох бусад журмыг дагаж мөрдүүлнэ.

2.2.9. Барилгын ажлаас гарсан хог хаягдлыг зайлуулах, зөөж тээвэрлэх, талбайн цэвэр цэмцгэр байдлыг хангахад идэвх санаачилгатай ажиллана.

2.2.10. Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажлыг хийж гүйцэтгэхдээ айл өрхтэй хүндэтгэлтэй, найрсаг харилцаж, ойлголцож ажиллана.

2.2.11. Төслийн бусад ББЖБЭ-тэй хамтран ажиллаж, харилцан туршлага солилцоно.

2.2.12. Төслийн түншлэгч, санхүүжүүлэгч байгууллагуудын зохион байгуулж буй

судалгаа, хяналт-үнэлгээнд оролцож, үнэн зөв мэдээллийг өгнө.

2.2.13. Төслийн санхүүжүүлэгч, түншлэгч байгууллагууд болон айл өрхийг үл хүндэтгэх, хууран мэхлэх, залилах, луйвардах, худал мэдээлэл тараах, гутаан доромжлох, дур мэдэн ажлаа дундаас нь орхих, дутуу гүйцэтгэх, архи, согтууруулах ундааг хэрэглэх зэрэг Ёс зүйн дүрэмд заасан аливаа зөрчил болон Монгол Улсын хууль тогтоомжид заасан гэмт хэргийн шинжтэй бүхий л үйлдлийг гаргахгүй байх, гэм буруутай үйлдэл гаргасан бол өөрөө болон бригад/компанийн гишүүнийхээ өмнөөс зохих хариуцлагыг хүлээх, гэм буруугийн хохирлыг бүрэн дүүрэн барагдуулна.

2.2.14. Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажлыг гүйцэтгэх явцад асууж тодруулах, шийдвэрлүүлэх шаардлагатай асуудал гарсан, тодорхойгүй, ойлгомжгүй зүйл болон гэнэтийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд МБҮА ТББ-тай холбогдох, өгсөн чиглэл, зөвлөмжийг авч хэрэгжүүлнэ.

2.2.15. Энэхүү Санамж бичиг-ийн хүчинтэй хугацаа дуусгавар болсон эсвэл аль нэг талын санаачилгаар цуцлагдсан байлаа гээд ББЖБЭ нь айл өрхтэй байгуулсан "Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ"-гээр хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой.

ГУРАВ. ХҮРЭХ ҮР ДҮН

3.1. Хамтын ажиллагааны үр дүнд хувийн сууцны дулаан алдагдлыг эрчим хүчний хэмнэлттэй технологиор бууруулах чадамжтай, тодорхой мэдлэг, бодит туршлагыг хуримтлуулсан, ёс зүйтэй ББЖБЭ болсон байна.

ДӨРӨВ. БУСАД НӨХЦӨЛ

4.1. “Санамж бичиг”-т нэмэлт, өөрчлөлтийг оруулж болох бөгөөд энэ тохиолдолд талууд нь бичгээр үйлдэж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. “Санамж бичиг”-ийн нэмэлт, өөрчлөлт нь энэхүү “Санамж бичиг”-ийн салшгүй хэсэг байна.

4.2. “Санамж бичиг”-ийг 2 хувь үйлдэж, талууд нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Талууд тус бүр нь нэг хувийг хадгална.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

НЭГ ТАЛААС:

.....

.....

НӨГӨӨ ТАЛААС:

.....

.....

Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажилд зуучлуулж буй барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчийн сар бүрийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт

Үндэслэл: Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид нь дулаалгын технологийн дагуу гэр хорооллын хувийн сууцыг дулаалж, дулаан алдагдлыг нь багасгах замаар агаарын бохирдлыг бууруулахад өөрийн хувь нэмрээ оруулж байна.

Зорилго: Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчдийн хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажлын гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, айл өрхийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг гаргав.

Д/Д	Шалгуур үзүүлэлтийн төрлүүд	Тайлбар
1	Техникийн үнэлгээ, дулаалгын ажлын гүйцэтгэл болон чанарын хяналт	45 оноо
1.1.	Сард хийсэн хэмжилт, үнэлгээний тоо	2-той тэнцүү байвал 2 оноо авна >2 дээш байх тохиолдолд нэмэлт тутамд 1 бонус оноо
1.2.	Сард хийсэн дулаалгын ажлын тоо	1-тэй тэнцүү байвал 10 оноо авна >=2 дээш байх тохиолдолд нэмэлт тутамд 10 бонус оноо
1.3	Хийсэн ТҮ нь дулаалгын ажил болсон тоо /өөрөө дулаалгын ажил хийж амжихгүй буюу өөр бригадад дулаалгын ажлаа шилжүүлсэн тохиолдолд. Гэрээ хийж, акт зөвшөөрсний дараа/	1-тэй тэнцүү байвал 5 оноо авна >=2 дээш байх тохиолдолд нэмэлт тутамд бонус 5 оноо
1.4	Дулаалгын үнэлгээний хуудас, тооцооллын эксел хэрэглэж байгаа байдал	Нийт ирүүлсэн ТҮ-ний гүйцэтгэлээс хамаарч 6 оноог хувьчилж өгнө
1.5	Чанарын хяналтын акт	Актууд зөвшөөрөгдсөн бол 16 оноо. Акт буцаагдсан тохиолдол бүрд 1 оноо хасах Буцаагдсан акт ажлын 5 хоногт засаж буцааж илгээгдээгүй бол 2 оноо хасах Буцаагдсан акт ажлын 14 хоногоос дээш хугацаанд засагдаж ирээгүй бол оноог тэглэнэ
1.6	Үнэлгээний маягт	Нийт ирүүлсэн үнэлгээний маягтыг гүйцэтгэлээс хамаарч, 6 ооонооос хувьчилж өгнө
2	Хэрэглэгчдийн сэтгэл ханамж	40 оноо
2.1	Хэмжилт, үнэлгээний талаарх сэтгэл ханамж	Сар бүрийн судалгаагаар авсан сэтгэл ханамжийн дундаж оноо 10 байна. Судалгаанд ТҮ хийлгэсэн айл өрхүүдийн хамгийн багадаа 60%-ийг хамруулна.
2.2	Дулаалгын ажлын талаарх сэтгэл ханамж	Сар бүрийн судалгаагаар авсан сэтгэл ханамжийн дундаж оноо 10 байна. Судалгаанд дулаалга хийлгэсэн айл өрхүүдийн хамгийн багадаа 60%-ийг хамруулна.
2.3	Дулаалгын зөвлөх, бригадын ахлагч гомдолгүй ажилласан байдал	Огт гомдол ирээгүй бол 20 оноо авна. Ирсэн гомдол тутамд түвшингээс нь шалтгаалан оноо хасна. Шар-5, Улбар шар-10, Улаан-15 оноо. Журамд заасан хугацаанд багтаан шийдвэрлэсэн бол түвшинээс нь шалтгаалан оноо нэмнэ. Шар-4, Улбар шар-8, Улаан-12 оноо. 5 оноо нэмнэ, Журамд заасан хугацааны дотор шийдвэрлээгүй бол 5 оноо хасна.
3	Идэвх оролцоо	20 оноо
3.1	Үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцсон байдал	Тухайн сарын үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхтэй оролцсон бол 15 оноо
3.2	Тухайн сард хийж гүйцэтгэсэн барилгын бусад ажлаа бүртгүүлсэн эсэх	>=1 дээш байх тохиолдолд 5 оноо
	Нийт	Нийт 105 оноо

ГОМДОЛ ХҮЛЭЭЖ АВАХ, БАРАГДУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Тус журам нь Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын ажил хийж гүйцэтгэх (цаашид “Аливаа захиалга” гэх)-тэй холбоотой айл өрхөөс төслөөр чадавхжиж, ажилд зуучлуулж буй барилгын бичил, жижиг бизнес эрхлэгч (цаашид “ББЖБЭ” гэх)-д ирүүлсэн гомдлыг шийдвэрлэхэд оршино.

1.2. Айл өрхийн гомдлыг албан ёсоор “Дуудлагын төв”, төслийн фэйсбүүк хуудас болон и-мэйл хаягаар дамжуулан ажлын өдрүүдэд (Даваа-Баасан: 09:00-18:00 цаг) хүлээн авна.

1.3. Гомдлыг хүлээн авсан даруйдаа холбогдох ББЖБЭ-д шуурхай дамжуулж, гомдлыг түргэн барагдуулах үүрэг чиглэлийг өгнө.

1.4. Хүлээн авсан гомдлыг хөнгөн, дунд, хүнд гэсэн 3 төвшинд ангилах бөгөөд (Хавсралт №1) гомдлын төвшнөөс хамаарч хариуцлага алдсан ББЖБЭ тохирох хариуцлагыг хүлээлгэнэ.

1.5. ББЖБЭ нь өөрт ирсэн гомдлыг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

1.6. ББЖБЭ нь айл өрхтэй тохирсон баталгаат хугацаа дуусах хүртэл өөрийн бруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гомдлыг шийдвэрлэх бөгөөд үүнд Төсөлтэй хамтын ажиллагааг дуусгавар болсон нь гомдлыг барагдуулахгүй байх үндэслэл болохгүй.

ХОЁР. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ, ЭС БАРАГДУУЛАХ

2.1. Айл өрхийн гомдлыг дараах тохиолдолд үндэслэлтэйд тооцож, барагдуулна. Үүнд:

2.1.1. ББЖБЭ нь аливаа захиалгыг хуваарилсан даруйд 3 ба түүнээс дээш хоног болоход холбогдоогүй;

2.1.2. Хүндэтгэх шалтгаангүй, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар аливаа захиалгыг гүйцэтгэхээр тохирсон цаг хугацаандаа эхлээгүй болон дуусгаагүй;

2.1.3. Аливаа захиалгыг гүйцэтгэхийн өмнө, явцад, дараа нь харилцаа, хандлагын тал дээр алдаа дутагдлыг гаргасан;

2.1.4. Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх хэмжилт, үнэлгээний дээд үнэ тарифыг хэтрүүлэн авсан, дулаалгын ажлын дундаж өртөг тооцооллоос өндөр тооцоолсон нь тогтоогдсон;

2.1.5. Аливаа захиалгад хамаарах техникийн бичиг баримт (Дулаалгын үнэлгээний хуудас, Дулаалгын ажлын акт, Хүлээлцэх акт, Комиссын дүгнэлт)-ыг айл өрхөд цаг тухай бүр нь хүлээлгэн өгөөгүй;

2.1.6. Аливаа захиалгыг дутуу эсвэл чанарын доголдолтой биелүүлсэн;

2.1.7. “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ”-гээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

2.1.8. Үндэслэлтэй гэж үзсэн бусад гомдлыг барагдуулна.

2.1.9. Айл өрхийн гомдлыг ББЖБЭ-ийн тайлбар, “Дуудлагын төв”-ийн айл өрхөөс авсан хариу, “Гомдол хаасан мэдэгдэл” (Хавсралт 2) зэрэг баримтад үндэслэн хаана.

2.2. Айл өрхийн гомдлыг дараах тохиолдолд үндэслэлгүйд тооцож, барагдуулахгүй. Үүнд:

2.2.1. “Дулаан шийдэл-2 төсөл”-ийн үйл ажиллагаа, цар хүрээнээс гадуурх барилгын бусад аливаа бүх төрлийн ажил болон хүсэлт, санал, гомдол;

2.2.2. Ашиг сонирхлын зөрчилтэй хүсэлт, гомдол гаргасан;

2.2.3. ББЖБЭ төдийгүй төслийн нэр хүндэд зориудаар халдсан аливаа худал мэдээлэл тараах гэх мэтийг үндэслэлгүйд тооцож, барагдуулахгүй.

Д/д	1. Гомдлын төвшин	
1	Хөнгөн төвшний гомдол	Захиалга өгсөн айл өрхийнд товлосон хугацаандаа очиж хэмжилт, үнэлгээг хийгээгүй эсвэл Дулаалгын үнэлгээний хуудсаа үлдээгээгүй (Сард нийтдээ 3 удаа)
		Айл өрхийн сэтгэл ханамжийн судалгаагаар хэмжилт, үнэлгээг хийсэн айл өрхийн талаас илүү хувь нь хэмжилт, үнэлгээнд сэтгэл хангалуун бус байсан нь тогтоогдсон (3 сар дараалан)
		Хэмжилт, үнэлгээний хөлсийг дур мэдэн нэмж авсан (Сард нийтдээ 3 удаа)
		Хэмжилтээ буруу хийж, улмаар үнэлгээгээ буруу гаргасан (Сард нийтдээ 3 удаа)
		Аливаа захиалгыг гүйцэтгэхийн өмнө, явцад, дараа нь харилцаа, хандлагын тал дээр алдаа дутагдал гаргасан бол (Сард нийтдээ 3 удаа)
		Дулаалгын ажил дууссаны дараа дулаалгын ажлын актыг айл өрхөд танилцуулахад ирүүлсэн аливаа гомдол (Нийтдээ 3 дулаалгын ажилд)
		Айл өрхтэй байгуулсан “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ”-гээр хүлээсэн үүргээ дутуу буюу дулаалгын ажлыг чанарын доголдолтой биелүүлсэн (Нийтдээ 3 дулаалгын ажилд)
		Үндэслэлтэй гэж үзсэн бусад хөнгөн төвшний гомдол (Сард нийтдээ 3 удаа)
2	Дунд төвшний гомдол	Захиалга өгсөн айл өрхөд товлосон хугацаандаа очиж үнэлгээ, хэмжилтийг хийгээгүй эсвэл Дулаалгын үнэлгээний хуудсаа үлдээгээгүй (Сард 4 ба түүнээс дээш удаа)
		Айл өрхийн сэтгэл ханамжийн судалгаагаар хэмжилт, үнэлгээ хийсэн айл өрхийн талаас илүү хувь нь хэмжилт, үнэлгээнд сэтгэл хангалуун бус байсан нь тогтоогдсон (4 ба түүнээс дээш сар дараалан)
		Хэмжилтээ буруу хийж, улмаар үнэлгээгээ буруу гаргасан (сард 4 ба түүнээс дээш тохиолдолд)
		Аливаа захиалгыг гүйцэтгэхийн өмнө, явцад, дараа нь харилцаа, хандлагын тал дээр алдаа дутагдал гаргасан бол (4 ба түүнээс дээш аливаа захиалгад)
		Дулаалгын ажил дууссаны дараа дулаалгын ажлын актыг айл өрхөд танилцуулахад ирүүлсэн аливаа гомдол (4 ба түүнээс дээш дулаалгын ажилд)

		Айл өрхтэй байгуулсан “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ”-гээр хүлээсэн үүргээ дутуу буюу дулаалгын ажлыг чанарын доголдолтой биелүүлсэн (4 ба түүнээс дээш дулаалгын ажилд)
		Үндэслэлтэй гэж үзсэн бусад дунд төвшний гомдол (Сард 4 ба түүнээс дээш удаа)
3	Хүнд төвшний гомдол	Дунд төвшний аль нэг болон аливаа гомдлын тоо хэтэрсэн
		Хэмжилтээ бууруу хийж, улмаар үнэлгээгээ бууруу гаргаснаас айл өрхөд санхүүгийн хүндрэл учруулсан ч түүнийгээ барагдуулахгүй бол
		Сануулах шийтгэлийг нийтдээ 3 удаа дараалан авсан
		Дулаалгын ажилдаа чанарын доголдлыг гаргасныа засахгүй эсвэл дулаалгын ажлаа дутуу гүйцэтгэх, хугацаатай үүрэг өгсөөр байтал биелүүлээгүй
		Төслийн талаар худал мэдээллийг тараасан
		Төслийн нэртэй хуурамч баримт бичгийг үйлдсэн
		Айл өрх нь тухайн ББЖБЭ-ийн аливаа үйлчилгээнд илтэд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн сэтгэгдлийг удаа дараа тасралтгүй илэрхийлсэн
		Үндэслэлтэй гэж үзсэн бусад хүнд төвшний гомдол
	2. Гомдлын төвшин бүрд оногдуулах хариуцлага	
1.	Хөнгөн төвшний гомдол	Утсаар эсвэл биечлэн сануулгыг өгөх
		Гомдлыг шийдвэрлэх хүртэл шинэ болон хуучин аливаа захиалгыг буруулах
2.	Дунд төвшний гомдол	Утсаар эсвэл биечлэн сануулгыг өгөх
		Гомдлыг шийдвэрлэх хүртэл шинэ болон хуучин аливаа захиалгыг хуваарилахгүй байх
3.	Хүнд төвшний гомдол	Хамтран ажиллахаас татгалзах талаар сануулгыг өгөх
		Хамтран ажиллахаас татгалзах

Гомдол хаасан мэдэгдэл

Гомдол гаргасан огноо: 202... Гомдол барагдуулсан огноо: 202...

Иргэн ..... овогтой ..... -ын/ийн гаргасан

.....

.....

гомдлыг дараах байдлаар барагдуулав.

Гомдлыг барагдуулсан тухай дэлгэрэнгүй тайлбар:

.....

.....

.....

.....

ББЖБЭ:

.....

Гарын үсэг

Иргэн:

.....

Гарын үсэг

БАРИЛГЫН БИЧИЛ, ЖИЖИГ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН БАРИМТАЛБАЛ ЗОХИХ ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

Барилгын бичил, жижиг бизнес эрхлэгч Би дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллана. Мөн өөрийн удирдаж буй баг бүрэлдэхүүндээ уг ёс зүйн зарчмыг танилцуулж, мөрдүүлэх болно. Үүнд:

- Монгол Улсын барилгын норм, дүрмийг баримтлан ажиллах;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг баримтлан ажиллах;
- Барилгын салбарын хөгжилд хувь нэмрийг оруулах, нийгмийн хариуцлагыг ухамсарлах;
- Үнэнч шударга, ил тод, нээлттэй, найрсаг харилцааг эрхэмлэх, аливаа сөрөг хандлагыг гаргахгүй, бусдын нэр төр, алдар хүндэд халдахгүй, хэн нэгнийг ялгаварлан гадуурхахгүй байх;
- Мэдлэг, ур чадвараа үргэлж хөгжүүлэх, туршлага, гүйцэтгэл, бүтээмжээ тасралтгүй дээшлүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийг ямагт эрхэмлэх;
- Нэг зорилгын төлөө өөр хоорондоо нэгдэж ажиллах, шударгаар өрсөлдөх, хамтдаа хөгжих;
- Аливаа ажил, үйлчилгээг үзүүлэхдээ мэргэжлийн мэдлэг, дадлага, туршлагаа бүрэн дайчилж, чанартай, найдвартай хийж гүйцэтгэх, эхлүүлсэн ажлаа дутуу орхихгүй байх, аливаа доголдолгүй ажиллах. Тухайлбал, айл өрхийн хувийн сууцны дулаан алдагдлыг зөв илрүүлэх, дулаалгын тооцооллыг үнэн бодитой гаргах;
- Хийж гүйцэтгэхэд мэдлэг, ур чадвар, туршлага нь дутах, гүйцэтгэх боломжгүй бол урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр тухайн ажил, үйлчилгээнээс татгалзах, эсхүл зөвлөх инженерийн удирдлаган дор гүйцэтгэх;
- “Харилцагчийн хүсэлтээр” гэх нэрийдлээр барилгын норм, дүрэмд нийцээгүй, технологийн бус аливаа ажлыг гүйцэтгэхгүй байх. Тухайлбал, дулаалга хийх боломжгүй хувийн сууцанд дулаалгын үнэлгээг гаргахгүй, дулаалгын ажлыг хийхгүй байх;
- Харилцагчтай байгуулсан аливаа гэрээний үүргийг биелүүлж, санхүүжилтийг зориулалтын дагуу ариг гамтай, хариуцлагатай зарцуулах;
- Хувийн ашиг сонирхол, ашиг хонжоог өөрийн ажил, мэргэжил, үзүүлж буй үйлчилгээнээс дээгүүрт тавихаас зайлсхийх, аль ч хэлбэрийн хүндрэл, дарамтыг учруулахгүй байх;
- Харилцагчтайгаа ашиг сонирхлын зөрчлийг үүсгэхээс урьдчилан сэргийлэх;
- Өөрөө оролцоогүй аливаа ажилд акт, дүгнэлт, тайлан, тайлбарыг өгөхгүй байх, гарын үсэг зурахгүй, хувийн тэмдгээ дарж баталгаажуулахгүй байх;
- Ажил, амралтаа зохицуулах;
- Ажлын гүйцэтгэлтэй холбоотой зүй ёсны аливаа шаардлагыг биелүүлэх;
- Барилгын хог хаягдлыг аль болох бага гаргах, боломжит хог хаягдлыг дахин боловсруулж ашиглах;
- Барилгын талбайд гэмтэл, бэртлээс өөрийгөө болон багийн гишүүдээ бүрэн урьдчилан сэргийлэх;
- Барилгын талбайд насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахгүй байх;
- Өөрийн олж авсан мэдлэг, мэдээллийн талаар бусдад зориудаар худал мэдээллийг тараахгүй, өгөхгүй байх;

ДУЛААЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

202... оны ...-р сарын ...-ний өдөр Дугаар: __/___ Улаанбаатар хот

Энэхүү “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ” (Цаашид “Гэрээ” гэх)-г
Нэг талаас: _____ дүүрэг, ____ хороо, _____ хороолол, _____ тоот хаягт оршин суух хаягтай_____ овогтой _____ (РД: _____), Утасны дугаар: _____ (цаашид “Захиалагч” гэх),
Нөгөө талаас: _____ дүүрэг, ____ хороо,_____ хороолол, хаягт байрлалтай (РД: _____), _____ овогтой _____ (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) нь Монгол Улсын Иргэний хуулийн 343.1 дэх хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчтай тохиролцсоны дагуу хувийн сууц (амины орон сууц, байшин)-ны үндсэн дулаалгын ажил (цаашид “Дулаалгын ажил” гэх)-ыг гэрээнд заасан хугацаанд технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэн Захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгөх, Захиалагч нь гэрээнд заасны дагуу төлбөр төлөх, дулаалгын ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих, ажлын гүйцэтгэлийн үр дүнг хүлээн авах зэрэг Талуудын эрх, үүрэгтэй холбогдон гарах харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Технологийн дагуу хийж гүйцэтгэх боломжтой дулаалгын ажлаас бусад барилгын бүх төрлийн ажил энэхүү гэрээгээр зохицуулагдахгүй бөгөөд хамаарахгүй болно.

ХОЁР. ДУЛААЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БАЙРШИЛ, ДУЛААЛГЫН ТӨРӨЛ БОЛОН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Дулаалгын ажил гүйцэтгэх байршил: _____ (цаашид “Ажлын талбай” гэх) байна.

2.2. Дулаалгын ажлын төрөл: _____

2.3. Дулаалгын ажил эхлэх, дуусах огноо: _____

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1. Гэрээгээр гүйцэтгэх дулаалгын ажлын нийт төлбөр нь _____ төгрөг байна. Энэхүү дүнд чанарын шаардлага хангасан дулаалгын үндсэн материал, туслах материал, тээврийн зардал, ажлын хөлс орсон бөгөөд технологийн дагуу хийж гүйцэтгэх боломжтой дулаалгын ажлаас бусад барилгын бүх төрлийн ажлын зардал ороогүй болно.

3.2. Дулаалгын материалын үнийн өсөлт, бараа материалын хомсдол гэх мэт шалтгаанаар дулаалгын ажлыг эхлүүлэхийн өмнө болон дулаалгын ажлын гүйцэтгэлийн явцад энэхүү гэрээний төлбөр өөрчлөгдөх бол Гүйцэтгэгч нь энэ тухайгаа Захиалагчид нэн даруй урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр тус гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

3.3. Захиалагч нь гэрээний төлбөрийг энэхүү гэрээний 3.4 дэх хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгчийн дор дурдсан дансанд шилжүүлнэ:
Данс эзэмшигчийн нэр: _____
Хүлээн авагчийн банк: _____
Хүлээн авагчийн банкны дансны дугаар: _____

3.4. Захиалагч нь гэрээний төлбөрийг өөрийн эх үүсвэрээр төлөх бол дулаалгын ажлыг эхлүүлэхээс хоёр (2) хоногийн дотор гэрээний нийт дүнгийн 80 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилгаа төлбөрийг Гүйцэтгэгчид төлнө. Үлдэгдэл 20 хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг Гүйцэтгэгч нь дулаалгын ажлыг бүрэн хийж дуусган, Захиалагчид “Дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт”-ыг танилцуулан, Талууд “Дулаалгын ажлыг хүлээлцэх акт” (Хавсралт №1)-ыг үйлдсэний дараа Гүйцэтгэгчид 1 (нэг) хоногийн дотор төлнө.

3.5. Захиалагч нь гэрээний санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагын зээлийн эх үүсвэрээр төлөх бол Гүйцэтгэгч нь дулаалгын ажлыг бүрэн хийж дуусган, Захиалагчид “Дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт”-ыг танилцуулан, Талууд “Дулаалгын ажлыг хүлээлцэх акт” (Хавсралт №1)-ыг үйлдсэний дараа банк, санхүүгийн байгууллага нь “Хэмнэлтийн гэрчилгээ”-г үндэслэн ажлын 1 (нэг) хоногийн дотор Гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийг шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь дараах эрхтэй. Үүнд:

4.1.1. Гүйцэтгэгчээс зөвхөн энэхүү гэрээнд заасан дулаалгын ажлыг чанарын шаардлага хангасан материалаар технологийн дагуу хийж гүйцэтгэхийг шаардах;

4.1.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

4.1.3. Гүйцэтгэгчээс дулаалгын ажлын үйл явцтай холбоотой мэдээллийг тухай бүрд авах, хяналт тавих;

4.1.4. Дулаалгын үндсэн материалд НӨАТ-ын баримт гаргаж өгөхийг Гүйцэтгэгчээс шаардах;

4.1.5. Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд хүлээсэн аливаа үүргээ ноцтой зөрчсөн нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх;

4.1.6. Дулаалгын ажил дууссаны дараа үлдсэн дулаалгын үндсэн материал, туслах материал нь Захиалагчийн өмч бөгөөд үлдээхийг Гүйцэтгэгчээс шаардах;

4.1.7. Гүйцэтгэгчийн олгосон баталгаат хугацааны дотор дулаалгын ажлын үр дүнд түүний буруутай ажиллагаанаас үүдэлтэй доголдол илэрсэн нь тогтоогдвол Гүйцэтгэгчид шаардлага тавин засуулах;

4.2. Захиалагч нь дараах үүрэгтэй. Үүнд

4.2.1. Гэрээнд заасны дагуу төлбөрийг төлөх;

4.2.2. Гүйцэтгэгчийг гэрээнд заасан хугацаанд чанарын шаардлага хангасан материалаар технологийн дагуу дулаалгын ажлаа хийж гүйцэтгэх боломж, нөхцөлөөр хангаж, Гүйцэтгэгчтэй хүндэтгэлтэй, зөв боловсон харьцах ба ажил гүйцэтгэх хугацаанд түүнд ямар нэгэн саад тотгор учруулахгүй байх, аливаа асуудал гарвал үүнийг эв зүйгээр зохицуулах, хоорондоо ойлголцохыг ямагт эрхэмлэх;

4.2.3. Чанарын шаардлага хангаагүй, хуучин дулаалгын материалуудыг барилгад буцаан угсрах, дахин ашиглах, технологийн биш дулаалгын ажил хийхийг Гүйцэтгэгчээс шаардахыг хатуу хориглоно.

4.2.4. Дулаалгын ажлыг хийхийн өмнө болон хийх явцад давагдашгүй хүчин зүйл (цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгалийн гамшиг, хорио цээр, үймээн гэх мэт) болон хүндэтгэх шалтгааны улмаас ажлын гүйцэтгэлийг хойшлуулах, түр зогсоох шаардлага үүсвэл энэ тухай Гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэж, гэрээний хугацааг харилцан тохиролцсоны үндсэн дээр сунгах, тухайн нөхцөл байдал арилсны дараа дулаалгын ажлыг бүрэн гүйцэтгүүлэх;

4.2.5. Дулаалга хийхээс өмнө болон хийх явцад барилгын бусад төрлийн нэмэлт ажил хийлгэх шаардлага үүсэх тохиолдолд Гүйцэтгэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр Нэмэлт гэрээ байгуулж, тус ажлыг гүйцэтгүүлэх;

4.2.6. Гэрээний дагуу дулаалгын ажлын үр дүнг хүлээн авч, Гүйцэтгэгчийн олгосон баталгаат хугацаа дуусснаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах;

4.2.7. Гүйцэтгэгчийн үйлдсэн Дулаалгын ажлын гүйцэтгэлийн акттай ажлын 3 (гурав) хоногийн дотор танилцсаны үндсэн дээр Хавсралт №1-д ажлын 3 (гурав) хоногийн дотор гарын үсэг зуран баталгаажуулах. Хэрэв дурдсан хугацаанд акттай танилцаагүй, акт үйлдээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцно.

4.2.8. Гүйцэтгэгч нь дулаалгын ажлын талбайг орхин явахдаа багаж хэрэгслээ үлдээсэн тохиолдолд Захиалагч нь тухайн багаж хэрэгсэл, материал, тоног төхөөрөмжийг аюулгүй, найдвартай газар хадгалах;

4.2.9. Дулаалгын ажил гүйцэтгэх явцад ашиглаж буй үндсэн материал, туслах материалыг аюулгүй газар хадгалах. Хадгалах үед дээр дурдсан материалууд, багаж, тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл учирсан, алга болсон эсхүл доголдол үүссэн тохиолдолд хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан төлнө.

4.2.10. Захиалагчийн бууртай үйлдлийн улмаас Гүйцэтгэгчийн технологийн дагуу хийсэн дулаалгын ажлын чанарт сөргөөр нөлөөлсөн, эвдрэл, гэмтэл үүссэн, дулаалсан сууцыг зориулалтын дагуу ашиглаагүйгээс үүссэн аливаа хохирлыг Захиалагч нь бүрэн хариуцах;

4.2.11. Дулаалгын ажил хийж байх явцад болон ажил дууссаны дараа гарсан барилгын аливаа хог хаягдлыг өөрийн зардлаар зөөж тээвэрлэх, зайлуулах үүрэгтэй бөгөөд энэ тухай Гүйцэтгэгчтэй тохиролцож болно.

4.2.12. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Гүйцэтгэгчид төлнө.

4.3. Гүйцэтгэгч нь дараах эрхтэй. Үүнд:
4.3.1. Гэрээнд заасны дагуу төлбөр төлөхийг Захиалагчаас шаардах;
4.3.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах;
4.3.3. Захиалагчаас дулаалгын ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг авах;
4.3.4. Дулаалгын ажлыг эхлүүлэхээс өмнө Захиалагчийн боломж, цаг завыг харгалзан, урьдчилан очиж гүйцэтгэх ажлын цар хүрээг тодорхойлох.

4.4. Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:
4.4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйгаа мөрдөж, гэрээнд заасан хугацаанд өөрийн баг, бүрэлдэхүүнээ бүрэн хариуцан, удирдан зохион байгуулж, дулаалгын ажлыг чанарын шаардлага хангасан материалаар технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх;
4.4.2. Захиалагчийг дулаалгын ажлын явцад хяналт тавих, ажлын үр дүнг хүлээн авах боломжоор хангах;
4.4.3. Энэхүү гэрээнд заасан дулаалгын ажлыг гүйцэтгэх явцад өөрийн буруутай ажиллагаанаас илэрсэн доголдол болон шаардлага хангаагүй ажлыг өөрийн хөрөнгөөр засаж, дахин гүйцэтгэх;
4.4.4. Дулаалгын ажилдаа ___ сарын баталгаат хугацаа олгох. Олгосон баталгаат хугацаанд нь өөрийн буруутай ажиллагаатай холбоотой доголдол илэрсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр засах;
4.4.5. Чанарын шаардлага хангаагүй, хуучин дулаалгын материалуудыг барилгад буцаан угсрах, дахин ашиглах, технологийн биш дулаалгын ажил хийхийг хатуу хориглоно.
4.4.6. Захиалагчтай хүндэтгэлтэй, зөв боловсон харьцах ба дулаалгын ажил гүйцэтгэх явцад аливаа асуудал гарвал үүнийг эв зүйгээр зохицуулах, хоорондоо ойлголцохыг ямагт эрхэмлэх;
4.4.7. Дулаалгын ажлыг хийхийн өмнө болон хийх явцад давагдашгүй хүчин зүйл (цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгалийн гамшиг, хорио цээр, үймээн гэх мэт) болон хүндэтгэх шалтгааны улмаас ажлын гүйцэтгэлийг хойшлуулах, түр зогсоох шаардлага үүсвэл энэ тухай Захиалагчид нэн даруй мэдэгдэж, гэрээний хугацааг харилцан тохиролцсоны үндсэн дээр сунгах, тухайн нөхцөл байдал арилсны дараа дулаалгын ажлыг бүрэн хийж дуусгах;
4.4.8. Дулаалгын ажил хийхээс өмнө болон хийх явцад барилгын бусад төрлийн нэмэлт ажил хийлгэх хүсэлт Захиалагч гаргавал түүнтэй харилцан тохиролцож, Нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр тус ажлыг гүйцэтгэх;
4.4.9. Захиалагчид дулаалгын үндсэн материалд НӨАТ-ын баримт гаргаж өгөх;
4.4.10. Дулаалгын ажил дууссаны дараа үлдсэн дулаалгын үндсэн материал, туслах материал нь Захиалагчийн өмч бөгөөд Гүйцэтгэгч нь үлдээх;
4.4.11. Дулаалгын үндсэн материал, туслах материалыг хадгалах, түүнтэй харьцах талаар зааварчилгаа зөвлөмжийг Захиалагчид өгөх;
4.4.12. Дулаалгын ажил хийх явцад барилгын аливаа хог хаягдлыг аль болох бага гаргахыг эрхэмлэх бөгөөд ажил дууссаны дараа үүссэн

барилгын аливаа хог хаягдлыг зөөж тээвэрлэх, зайлуулах асуудлыг Захиалагчтай харилцан тохиролцож болно.

4.4.13. Гүйцэтгэгч нь тодорхой шалтгаангүй, урьдчилж мэдэгдээгүй байж Захиалагчтай тохиролцсон хугацаандаа талбай дээр ажиллаагүй, гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэж дуусаагүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагчид төлнө.

ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

5.1. Талуудын аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ үл биелүүлсний улмаас учирсан аливаа хохирлыг нөгөө талдаа нөхөн төлнө.

5.2. Талууд нь энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг гуравдагч талын оролцоогүйгээр эв зүйгээр шийдвэрлэхийг хичээнэ. Талууд нь бүх талаараа нөгөө талынхаа нэр хүндийг хамгаалахыг эрмэлзэнэ.

5.3. Талууд нь аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1. Энэхүү гэрээ нь Хавсралтын хамт хүчинтэй байна. Энэхүү гэрээнд Талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2. Талууд гэрээний хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болсонд тооцно.

6.3. Энэхүү гэрээг Талууд тус бүр нэг хувь хадгалах бөгөөд гэрээний хувь бүр нь адил хүчинтэй байна.

6.4. Талууд урьдчилан тохиролцсоны үндсэн дээр аливаа нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэх бөгөөд тус нэмэлт, өөрчлөлтөд Талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчинтэй болно.

6.5. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь үндсэн гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

6.6. Талууд аль нэг талынхаа зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.7. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад ямар нэгэн байдлаар задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Овог нэр: _____
Албан тушаал: _____
Хаяг: _____
Регистрийн дугаар: _____
Утас: _____
Гарын үсэг: _____

Захиалагчийг төлөөлж:

Овог нэр: _____
Албан тушаал: _____
Хаяг: _____
Регистрийн дугаар: _____
Утас: _____
Гарын үсэг: _____

ДУЛААЛГЫН АЖЛЫГ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

20...оны ... сарын ...-ны өдөр Дугаар Улаанбаатар хот _____ аймаг/хотын _____ сум/дүүргийн _____ дугаар баг/хорооны ___ _____ гудамжны ____ дугаар тоотод баригдсан ____ м2 талбай бүхий сууц (амины орон сууц, байшин)-ны зориулалттай, Захиалагч _____ овогтой _____ -ынд хийж гүйцэтгэсэн дулаалгын ажлыг хүлээлцэх актыг 202... оны ... сарын ... -ны өдөр үйлдэв. Энэхүү актаар дараах хүснэгтэд тэмдэглэгдсэн дулаалгын ажлыг хүлээлцэнэ. Хүлээлцэж буй дулаалгын төрлийг өмнөх хүснэгтэд гэж тэмдэглэнэ. Үүнд,

Дулаалгын төрөл		Тайлбар	Захиалагч гүйцэтгэлийн акттай танилцсан огноо
	Дээврийн дулаалга		
	Ханын дулаалга		
	Суурийн дулаалга		
	Шалны дулаалга		

Дулаалгын ажлын гүйцэтгэлийн акттай /цахим хэлбэртэй/ танилцаж, хүлээн зөвшөөрсөн:
Захиалагч: .....
Дулаалгын ажлыг хүлээж авсан:
Захиалагч: .....
Дулаалгын ажлыг хүлээлгэж өгсөн:
Гүйцэтгэгч: .....

Дулаалгын материалтай харьцах талаар айл өрхөд өгөх ерөнхий зөвлөмж:

- Дээврийн дулаалгад эвдрэл гэмтэл гарахаас зайлсхийхийн тулд дээвэр дээр гарах гарцыг хязгаарлана. Зөвхөн дээвэр дээр гарах журам, анхааруулгыг сайн мэддэг эрх бүхий этгээдийг дээвэр дээр гарахыг зөвшөөрнө.
- Дээврийн дулаалгыг суурилуулсны дараа хүнд зүйл, тавилга тавихгүй байх. Зөвхөн хувийн сууцны гадна радиогийн антен, хиймэл дагуулын таваг, бусад механик тоног төхөөрөмжийг суурилуулахыг зөвшөөрнө.
- Айл өрх нь дулаалгын материал дээр ус дусаахгүй байна. Учир нь энэ нь дулаалгын чанарыг муутгах ба дээврийн нэлээд хэсгийг гэмтээх аюултай. Борооны ус дулаалгын материалыг гэмтээхээс урьдчилан сэргийлэхийн тулд дээврийн хаалтыг байнга хаалттай байлгана.
- Хана, сууринд дулаалгын материалыг гэмтээх, ус орохоос урьдчилан сэргийлэхийн тулд нүх гаргахгүй байх. Хананы агааржуулалтын нүхийг бөглөхгүй байх. EPS хөөсөнцөр хананы тухайд хана руу цохихгүй байх. Хананд ойрхон гал гаргахгүй байх.
- Суурийн металл ус тусгаарлагч дээр гишгэхгүй байх гэх мэт.

V. ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫГ ИЛРҮҮЛЭХ, ДУЛААЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД МӨРДӨХ ЗӨВЛӨМЖ

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ТУХАЙ:



Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд оруулахгүй байх



Ажлын хувцас өмсөх, хамгаалалтын бүс, хувийн хамгаалах хэрэгслийг зайлшгүй хэрэглэх



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдах

ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫГ ИЛРҮҮЛЭХ ХЭМЖИЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗАХИАЛГА ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ:

- Захиалгыг хуваарилсан даруйд нь айл өрхтэй аль болох түргэн шуурхай холбогдох, найрсаг харьцах, эргэх холбоотой байх
- Дэлгэрэнгүй мэдээллийг өгөх
- Захиалгыг гүйцэтгэх өдөр, цагийг товлох
- Айл өрхийн хаяг, байршлыг сайтар тэмдэглэж авах
- Захиалгыг хуримтлуулахгүй байх
- Чанартай, найдвартай, иж бүрэн, үнэн зөв үйлчилгээг үзүүлэх
- Технологийн дагуу дулаалах боломжтой эсэхийг тодорхойлж, боломжтой гэж үзвэл хэмжилт, үнэлгээг хийх
- Хэрэв технологийн дагуу гүйцэтгэх боломжгүй бол зөвлөгөөг өгөх
- Хувийн сууцны хаших бүтээцүүдийн хэмжээсийг зөв хэмжих
- “Дулаалгын өртөг тооцоолол”-ын дагуу үнэн, бодит үнэлгээг гаргаж өгөх
- Дулаалгын үнэлгээний хуудас, Хувийн сууцны үнэлгээний маягтыг бөглөх
- Хэрэв мэдлэг, мэдээлэл нь дутвал зөвлөх инженер, туршлагатай дулаалгын зөвлөх, бригадын ахлагчдаас зөвлөмжийг авах
- Айл өрхийн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх.

ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААЛГЫН АЖИЛ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ:

- Технологийн дагуу дулаалга хийх боломжтой бол “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ”-г зайлшгүй байгуулах
- Айл өрхтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, дулаалгын ажлыг заасан хугацаанд нь найдвартай, чанартай хийж гүйцэтгэх
- Дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт, хүлээлцэх актыг үйлдэх
- Айл өрхийн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх
- Баталгаат хугацаандаа шаардлагатай засвар, үйлчилгээг хийж гүйцэтгэх.

ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДЭД ОЛГОДОГ БАГАЖ, ХЭРЭГСЭЛ, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ:

- Багажны цүнх
- Гигрометр
- Лазерметр
- Гадаргуугийн термометр
- Төслийн танилцуулга
- Тараах материал
- Хавтас
- Үнэлгээний хуудас, эксел тооцоолол
- Дулаалгын зөвлөх, бригадын ахлагчдад өгөх зөвлөмж
- Энгийн/камертай хэмжилт, үнэлгээний үнэ тариф
- Төслийн дүрэм, журмууд
- Санамж бичиг
- Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ

ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫГ ИЛРҮҮЛЭХ КАМЕР/ЭНГИЙН ХЭМЖИЛТ, ҮНЭЛГЭЭГ ХИЙХ БАЙРШИЛ, ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХИЙН ҮНИЙН САНАЛ:

Д/д	Байршил (Улаанбаатар хот)	Хэмжилтийн төрөл	Үнийн санал (₮)
1.	Хот дотор буюу эцсийн буудал хүртэл	Энгийн	30,000
		Камер	50,000
2.	Эцсийн буудал	Энгийн	40,000
		Камер	60,000
3.	Зуслангийн бүс (Хандгайт, Яргайт гэх мэт)	Энгийн	40,000-50,000
		Камер	70,000
4.	Хотоос зайдуу	Энгийн	50,000-70,000
		Камер	70,000-100,000

ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААЛГЫН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХӨЛС:

Д/д	Дулаалгын ажлын төрөл	Үнийн санал (1м2, ₮)
1.	Дээвэр	15,000
2.	Хана	35,000
3.	Суурь	35,000
4.	Шал	35,000

ДУЛААЛГЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧ КОМПАНИУД БОЛОН ДУЛААЛГЫН МАТЕРИАЛЫН ТӨРЛҮҮД:

Д/д	Дулаалгын үндсэн материал нийлүүлэгч компанийн нэр	Дулаалгын материалын төрлүүд
1.	Эко вүүл ХХК	Ноосон дулаалга
2.	Росторг	Эрдэс хөвөн (Экоролл Росторг)
3.	Базалт	Чулуун хөвөн (Базалт вуул)
4.	Росторг	Эрдэс хөвөн хавтгай 0.40 (Кнауф Росторг)
5.	Росторг	Эрдэс хөвөн хавтгай 0.37 (Кнауф Росторг)
6.	Гэгээн өргөө ХХК	Америк эрдэс хөвөн
7.	Пирамид индастри	EPS хөөсөнцөр хавтан 21-22кг
8.	Росторг	XPS хөөсөнцөр хавтан
9.	Кнауф	EPS хөөсөнцөр хавтан
10.	Росторг	Хуванцар-польш сайдинг
11.	Росторг	Хуванцар-орос шинэ сайдинг
12.	Росторг	Төмөр сайдинг
13.	Старвиндов	SHIDE
14.	Старвиндов	Герман
15.	Бингл Спид	SHIDE

ХУВИЙН СУУЦНЫ ДУЛААН АЛДАГДЛЫГ ИЛРҮҮЛЭХ, ДУЛААЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕИЙН БАРИМТ БИЧИГ БҮРДҮҮЛЭЛТ, ВЭБ СИСТЕМ АШИГЛАХ ТУХАЙ:

1. Дулаалгын зөвлөхөд хэмжилт, үнэлгээг хуваарилснаас хойш 1 хоногийн дотор айл өрхтэй холбогдож, хэмжилт, үнэлгээг хийх хугацаагаа товлож, вэб системдээ оруулна.

2. Дулаалгын зөвлөх нь хэмжилт, үнэлгээг хийхдээ “Хувийн сууцны үнэлгээний маягт”-ыг вэб системээр хандан бөглөнө.

3. Дулаалгын зөвлөх нь хэмжилт, үнэлгээг хийхдээ дулаалгын ажлын үнэлгээг “Дулаалгын үнэлгээний хуудас” дээр бичиж, айл өрхөд 1 хувийг үлдээж, эх хувийн зургийг авч вэб системдээ оруулна.

4. Дулаалгын зөвлөх нь дулаалгын ажлыг эхлэхийн өмнө буюу багадаа 1-3 хоногийн өмнө “Дулаалгын ажил гүйцэтгэх гэрээ”-г айл өрхтэй хийнэ.

5. Дулаалгын ажлын гүйцэтгэлийн акт нь зөвшөөрөгдсөн бол айл өрхтэй “Дулаалгын ажлыг хүлээлцэх акт”-ыг үйлдэнэ.

6. Дулаалгын зөвлөх нь удирдсан, гардан гүйцэтгэсэн дулаалгын ажлаа технологийн дагуу хийж, үе шат бүрээ зургаар баримтжуулж, ажлаа дууссаны дараа вэб системээрээ холбогдох дулаалгын ажлын гүйцэтгэлийн актуудыг 1-3 хоногийн дотор бөглөж илгээнэ.

БАНК БОЛОН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛЭЭР ДУЛААЛГЫН АЖИЛ ХИЙЛГЭХ АЙЛ ӨРХӨД ХЭМЖИЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛС:

- Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх хэмжилт, үнэлгээ хийлгэж буй айл өрхөөсөө дулаалгын ажлаа хувийн санхүүжилтээр эсвэл зээлээр санхүүжүүлэх эсэхийг нь зайлшгүй асуух
- Хэрэв банк, санхүүгийн байгууллагын ногоон зээлээр дулаалуулах хүсэлтэй байгаа бол 20 ба түүнээс дээш хувиар эрчим хүчний хэмнэлт үүсгэх, дулаалгын технологийн дагуу гүйцэтгэх боломжтой үндсэн дулаалгын бүтээгдэхүүнүүдээ санал болгох
- Хувийн сууцны дулаан алдагдлыг үнэн зөв илрүүлж, хэмжилт, үнэлгээгээ бүрэн гүйцэд хийсний дараа дулаалгын үнэлгээний хуудсан дээр зөвхөн үндсэн дулаалгын үнийн дүн бичих, барилгын бусад ажлын үнэлгээг тусад нь тооцдогийг хэлэх
- Дулаалгын үндсэн материалыг гэрээт нийлүүлэгчдээс авч, дулаалгын технологийн дагуу дулаалга хийх боломжтойг сайтар тайлбарлах
- Зээлийг зориулалтын бусаар ашиглах боломжгүй, зөвхөн дулаалгын технологийн дагуу хийгдэх дулаалгын ажилд зээл олгох боломжтой байдгийг сайн ойлгуулах. Өөрөөр хэлбэл, зээлийн шийдвэр гарлаа гэхэд айл өрх рүү зээлийг шилжүүлдэггүй, дулаалгын ажил дуусаж, “Хэмнэлтийн гэрчилгээ” гарсны дараа дулаалгын ажлын хөлс болон материалын зардлуудыг холбогдох талуудад шилжүүлдэг гэдгийг мэдээлэх
- Төсөлтэй хамтрагч санхүүгийн байгууллагуудын мэдээлэлтэй урьдчилан уншиж танилцах.
- Хамтран ажиллагч ББСБ-ын 5 сая хүртэлх төгрөгийн зээлийн дүнд ногдох хүүгийн төлбөрийн 50%-ыг Дулаан шийдэл төслөөс хариуцна гэдгийг хэлэх.

ХААН БАНК

ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 20 сая хүртэлх
- 30 сар хүртэлх хугацаатай
- Жилийн 14.4%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Долоон буудал
- Бөхийн өргөө
- Да хүрээ
- Их цайз
- Толгойт
- Баянхошуу
- Цагдаагийн академи
- Нисэх
- Сонгинохайрхан
- Яармаг

ХАСБАНК

Амьдралд - ашиг хамтдаа.

ХЭРЭГЛЭЭНИЙ НОГООН ЗЭЭЛ

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 20 сая хүртэлх
- 30 сар хүртэлх хугацаатай
- Жилийн 15.6%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Хасбанкны Улаанбаатар хот дахь бүх салбар

ТӨРИЙН БАНК

ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 15 сая хүртэлх
- 30 сар хүртэлх хугацаатай
- Жилийн 12-14.4%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх
- Цалин, түүнтэй адилтгах орлогын 60%-иас хэтрэхгүй дүнгээр зээлээ хуваарийн дагуу хэсэгчлэн төлөх чадвартай
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Төрийн банкны Улаанбаатар хот дахь бүх салбар

БОГД БАНК

ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 50 сая хүртэлх
- 30 сар хүртэлх хугацаатай
- Жилийн 22.8-25.2%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Богд цамхаг
- Их тойруу
- Улаан хуаран
- Мишээл
- Драгон
- Хархорин

КАПИТРОН БАНК

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- 30 сар хүртэлх хугацаатай
- Жилийн 15.6%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Сүүлийн 6 сарын хугацаанд ажил бизнес тогтвортой эрхэлсэн байх
- Бизнесийн орлоготой бол тасралтгүй 6 сар бизнесээ эрхэлсэн байх
- Зээлийн муу түүхгүй байх
- Зээлийн хугацаанд эд хөрөнгийн даатгалд хамрагдахыг зөвшөөрсөн байх

САЛБАР НЭГЖ

- Капитрон банкны Улаанбаатар хот дахь бүх салбар

GSB CAPITAL

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- Дулаан шийдэл төслийн хөнгөлөлт
- 30 сар хүртэлх хугацаатай
- Сарын 2.4%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Тогтмол эх үүсвэртэй байх
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Да хүрээ
- Сүхбаатар салбар
- 21-р хороолол

VisionFund MONGOLIA

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- Дулаан шийдэл төслийн хөнгөлөлт
- 24 сар хүртэлх хугацаатай 3 сая хүртэл барьцаагүй
- Сарын 3.5%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Тогтмол эх үүсвэртэй байх
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Вишнфанд ББСБ-ын Улаанбаатар хот дахь бүх салбар

ТРАНСКАПИТАЛ

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

- Дулаан шийдэл төслийн хөнгөлөлт
- 24 сар хүртэлх хугацаатай
- Сарын 2.49-2.99%-н хүүтэй

ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА

- Тогтмол эх үүсвэртэй байх
- Зээлийн муу түүхгүй байх

САЛБАР НЭГЖ

- Транскапитал ББСБ-ын Улаанбаатар хот дахь бүх салбар

ДЭЭВЭР, АДРЫН ХӨНДИЙН ДУЛААЛГЫН АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ БУЮУ ЗУРГАН БАРИМТ ҮҮСГЭХ ЖАГСААЛТ:



ДУЛААЛГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

- Адрын хөндийд байрлах үнс, шар шавар, үртэс картон цаас, керамзит зэргийг буулгаж цэвэрлэх
- Үжилд орсон элементийг сольж хүчитгэх
- Дээвэр ус нэвтрэхээргүй байгаа эсэх, яндан орчмын хоолойн битүүмжийг нягтлах
- Бусад



ДУЛААЛГЫН ҮНДСЭН АЖИЛ:

- Уур тусгуурлагч хуудсан материал дэвсэж, залгаасуудыг зөрүүлж наалддаг туузаар наах
- Дулаалгыг адрын хучилтын дагуу жигд заагдсан зузааны дагуу ам даруулж дэвсэх
- Ус тусгаарлагч материалаар бүрэх (хурын ус дусаж болзошгүй эрсдлээс хамгаалж)
- Адрын хөндийн агаар сэлгэлтийг нэвт, хангалттай хийгдэх нээлхий хийх

ХАНАНЫ ХОЛБОЛТТОЙ ДУЛААЛГЫН АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ БУЮУ ЗУРГАН БАРИМТ ҮҮСГЭХ ЖАГСААЛТ:





ДУЛААЛГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

- Хуучин элс цементэн тэгшилгээний суларсан хэсгийг буулгах
- Буулгасан болон онгорхой хэсгүүдийг элс цементэн зуурмагаар тэгшлэх
- Гадаргууг тэгшилж, тоос шороонооос цэвэрлэх

ДУЛААЛГЫН ҮНДСЭН АЖИЛ:

- Хөрсжүүлэгчийг бүх гадаргууд жигд түрхэх
- Хөөсөнцөр хавтангийн дотор талд цавуут зуурмагийг жигд түрхэж, хананд наах
- Хадаас буюу механик бэхэлгээг тогтоосон зайтайгаар хадаж бэхлэх
- Хаалга, цонх, барилгын гадна хананы дотор болон гадна булангуудад нэмэлт бэхэлгээний тор наах
- Хаалга, цонхны дотор болон гадна булангуудад цууралтаас хамгаалах нэмэлт тор наах
- Хүчитгэх торыг гадна цавуут зуурмагт живүүлэх байдлаар жигд хийх
- Хөрсжүүлэгчийг бүх гадаргууд жигд түрхэх
- Гадна өнгөлгөө 15 см хөөсөнцөр болон чулуун замаск хийх

АГААР СЭЛГЭЛТТЭЙ ХАНЫН ДУЛААЛГЫН АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ БУЮУ ЗУРГАН БАРИМТ ҮҮСГЭХ ЖАГСААЛТ:







ДУЛААЛГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

- Дулаалгын материалыг бэхлэхийг хориглосон дранкт шавардлага, 12 см-ын тоосгон хана, фасадны элементүүдийг буулгах
- Гадаргууг тэгшилж, тоос шороонооос цэвэрлэх

ДУЛААЛГЫН ҮНДСЭН АЖИЛ:

- 1-р үе модон (металл) аргийг дулаалгын материалын өргөний хэмжээнд тааруулан бэхэлж, дулаалгын материалаар дүүргэх
- 2-р үе модон (металл) аргийг бэхэлж, дулаалгын материалаар дүүргэх
- 3-р үе модон (металл) аргийг бэхэлж, дулаалгын материалаар дүүргэх
- Ус чийг тусгаарлагчаар бүрж битүүмжлэн наах
- Агаарын үеийг гүйцэтгэж, гадна өнгөлгөөний хавтан угсрахад бэлтгэж тэгшлэх
- Гадна өнгөлгөөний хавтан хийх. Хаалга, цонхны амалгааг хийх. Ус тусгаарлагч болон усны хаялга төмрийг хийх

СУУРИЙН ХОЛБОЛТТОЙ ДУЛААЛГЫН АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ БУЮУ ЗУРГАН БАРИМТ ҮҮСГЭХ ЖАГСААЛТ:






ДУЛААЛГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

- Суурийн бетон хаяавчийг буулгаж зайлуулах
- Суурийн нягтаршуулсан хөрсийг хамгийн багадаа 30 см гүнтэй ухах
- Суурийн бетоныг цэвэрлэж бэлтгэх
- Бусад

ДУЛААЛГЫН ҮНДСЭН АЖИЛ:


- Суурийн бетоныг цэвэрлэж, ус тусгаарлагчийг түрхэх
- XPS дулаалгын хавтанг 10 см зузаантай хийх
- Суурийн хөрстэй харьцаж буй хэсгийн дулаалгын хавтанг ус тусгаарлагчаар хамгаалан хөрсөөр нягтаршуулан дарах
- Газрын гадаргаас ил гарсан хэсгийг гадны механик гэмтлээс хамгаалж, керамик хавтанг наах

ШАЛНЫ ДУЛААЛГЫН АЖЛЫН ТЕХНОЛОГИЙН ДАРААЛАЛ БУЮУ ЗУРГАН БАРИМТ ҮЗҮҮЛЭХ ЖАГСААЛТ:



ДУЛААЛГЫН БЭЛТГЭЛ АЖИЛ:

- Модон шалыг хуулах
- Ургамлын үндэстэй хөрсийг зайлуулах
- Суурийн даацын элементэд хүчитгэл хийх
- Хэрэв дотор хананы суурийн хэсэг нь модон хийц бол түүнийг зайлуулж, бетон суурь цутгах
- Буурийг бэлтгэж нягтруулах
- Элсэн үе дэвсэх



ДУЛААЛГЫН ҮНДСЭН АЖИЛ:

- Дайрган үе дэвсэж нягтруулан өндөржилт таарууулах
- Ус чийг тусгаарлагчийг хийх
- Дулаалгын материал (XPS)-ыг 10 см зузаантай дэвсэж хийх
- Бетон цутгалтыг гүйцэтгэх
- Шалны бетонд температурын заадас гаргах

ДУЛААЛГА ХИЙХ БОЛОМЖГҮЙ БАЙШИНГИЙН ХИЙЦЛЭЛҮҮД

Дараах хийцлэлтэй байшинд дулаалга хийх боломжгүй, дулаалгын өртөг тооцоолол гаргаж өгөхгүй байхыг АНХААРУУЛЖ БАЙНА.

Үүнд:

- Нүхт блок ханын хийцтэй
- Цэвдэгтэй газарт баригдсан барилга гэмтсэн
- Хана нурсан эсвэл хагарал явагдсан
- Адрын хөндийн модон элемент ялзарсан
- Суурь хагарсан /ханын хамт/
- Модон хана дранктай шавардлага
- Хана гадна талаараа тоосгон өнгөлгөөтэй /тэрэн дээрээ дулаалга хийлгэх бол/

Ийм хийцлэлтэй байшинтай айл өрхөд зөвлөгөө өгч, дулаалга хийх боломжгүйг хэлж, дулаалгын өртөг тооцоолол гаргахгүй, дулаалгын үнэлгээний хуудас гаргаж өгөхгүй гэдгийг анхааруулах. Дулаалга хийсэн ч үр ашиггүй хөрөнгө оруулалт болно гэдгийг айл өрхдөө хэлээрэй. Хэрэв ийм хийцлэлтэй байшинд дулаалга хийх боломжтой гэж үзэн дулаалгын үнэлгээ гаргаж өгсөн бол үүнээс үүсэх асуудал, эрсдэлийг бичил, жижиг бизнес эрхлэгч өөрөө хариуцах болно.

7505-2000 ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ dulaanshiideltusul@gmail.com

ДУЛААН ШИЙДЭЛ
SWITCH OFF AIR POLLUTION

“ТАВ ТУХТАЙ ОРЧНЫГ ТАНЫ БАЙШИНД”
“ДУЛААН ШИЙДЭЛ-2 ТӨСӨЛ”

